



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/68/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn Аудитор: С.Санчирмаа Утас: 99282488 Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024. 02. 05 № 17

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цээл сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цээл сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргын захирамжаар "Нээлттэй Алтай" хөтөлбөрийн хүрээнд шинээр гэр бүл болсон малчин залууст дэмжлэг үзүүлж өрх тус бүрийг 50 толгой эм ямаагаар малжуулах ажлыг зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 85,552.8 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин, хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 6 зорилт, 97 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 63 арга хэмжээг бүрэн, 24 арга хэмжээг 90.0 хувь, 5 арга хэмжээг 70.0 хувь, 1 арга хэмжээ 50.0 хувь, 2 арга хэмжээ 30.0 хувь, 2 арга хэмжээ хэрэгжээгүй буюу нийт дүнгээр 93.8 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд Цээл сумын Засаг дарга 90.7 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

. 070200008

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	58,994.6	57,373.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,447,823.5	2,063,169.1
	Нийт хөрөнгийн дүн	1,506,818.1	2,120,542.3
	Нийт өр төлбөрийн дүн	-	26,655.3
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,506,818.1	2,093,887.0
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,506,818.1	2,120,542.3
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,083,971.5	1,402,598.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	609,020.5	815,529.8
	Үйл ажиллагааны үр дүн	474,951.0	587,068.9
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	474,951.0	587,068.9
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,031,867.1	1,506,818.1
	Тайлант оны үр дүн	474,951.0	587,068.9
	Эцсийн үлдэгдэл	1,506,818.1	2,093,887.0
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	473,289.9	693,261.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	473,089.9	647,291.2
	Үйл ажиллагааны ЦМГ	200.0	45,970.6
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(200.0)	(45,970.6)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	659,497.2	535,223.4
	Урсгал зардал	659,497.2	535,223.4
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	659,497.2	546,665.2
	Улсын төсвөөс санхүүжих	-	-
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	659,497.2	546,665.2

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар бүртгэл тайлагналын алдаа илрээгүй байна Залруулсан алдаа

Залруулагдаагүй нийт 17,652.9 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 17,652.9 мянган төгрөгийн 6 зөрчил¹ илэрснээс, 17,652.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар 5 албан шаардлага, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт 12,685.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитаар нийт 12,685.0 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс, 12,685.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар 4 албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага өгсөн.

Албан шаардлага

1. Хувь хүний орлогын албан татварын тайланг 2,535.0 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан нь "Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хувь хүний орлогын албан татварын тайланг үнэн зөв тайлагнаж, биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

2. Хантайшир 100 жилийн ойн арга хэмжээтэй холбоотойгоор бараа материал худалдан авч 7,400.0 мянган төгрөгийн зардлыг шууд зардалд бичсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг ангиллын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Шинэ суурьшлын бүсийн мод арчилгаа, усалгаа хийлгэхээр иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээнээс татвар, нийгмийн даатгалыг суутгаж төлөөгүй нь "Хөдөлмөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.4-т "Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг холбогдох талууд дагаж мөрдөх үүрэгтэй." Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Хууль эрх зүйн хүрээнд холбогдох татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

4. Байгаль хамгаалах нөхөн сэргээх сангийн зардлаас 2,750.0 мянган төгрөгийн мод усалгааны ажилтны хөлсийг төлсөн нь "Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралтын 3 дугаар зүйлийн 3.7-т "Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг ангиллын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

5. Өмнөх шийдвэрээс 2023 оны 02 сарын 24-ны өдрийн 01/41, 05/41, 06/41 дугаартай төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”; Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Өмнөх шийдвэрийг хэрэгжүүлээгүй Засаг даргын Тамгын газрын дарга Б.Насанбуян, нягтлан бодогч Г.Чоймаа нарт хуулийн дагуу хариуцлага тооцож, өмнөх шийдвэрийг хэрэгжүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цээл сумын Засаг даргын Тамгын газар	5	12.7	-	-	4	12.7	-	-	1	2		
Дүн	5	12.7	-	-	4	12.7	-	-	1	2		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			